



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 4/551

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Тусгай Олимпын хорооноос оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад урам дэм өгөх, бие бялдрыг нь хөгжүүлэх, нийгэмшүүлэх зорилгоор зохион байгуулагдах Хангайн бүсийн “Боломжийг бүгдэд нь II” арга хэмжээнд аймгаас оролцох багийн зардалд 3,000,000 (Гурван сая) төгрөг, өөрийн гэсэн орон гэргүй гэр олгохыг хүссэн Мөрөн сумын иргэн Ганболдын Мягмарсүрэнд 300,000 (Гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 3,300,000 (Гурван сая гурван зуу мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ